

УЛС ТӨР, ОЛОН
УЛСЫН ХАРИЛЦАА

**БНМАУ, БНХАУ-ЫН
ХООРОНДЫН НАЙРАМДАЛ,
ХАРИЛЦАН ТУСЛАЛЦАХ ТУХАЙ
ГЭРЭЭ БА МОНГОЛ,
ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ**

Ж. Бямбасүрэн

Хүн төрөлхтөн дэлхийн хоёрдугаар дайны уршиг дагавраас бүрэн ангижирч чадаагүй байсан 1950, 60-аад оны үед тив тивийн улс түмэн аливаа дайн түрэмгийлэл, милитаричлалаас зайлсхийж, амар тайван амьдрах хүсэл эрмэлзэлтэй байлаа. Азийн улс орнууд ч хоорондын харилцааны хэм хэмжээг тодорхойлсон Панча Шила буюу энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим, Бандунгийн 10 зарчим зэргийг 1950-иад оны дундуур дэвшүүлж, нийт энхийг эрхэмлэгчдийн дэмжлэгийг хүлээсэн юм.

Монгол, Хятадын харилцааны ид хөгжлийн үе буюу БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд Жоу Энълай манай оронд айлчлан ирсэн 1960 оны 5-р сарын 31-нд «БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах тухай Гэрээ»-нд хоёр тал Улаанбаатар хотноо гарын үсэг зурж, тус хоёр орны харилцааны үндсэн зарчим чиглэлийг заан тодорхойлсон нь дээр дурдсан зарчмуудын үзэл санаанд бүрэн нийцсэн бөгөөд манай хоёр хөрш орны цаашдын харилцааны эрх зүйн үндэс болсон юм.

Оршил хэсэг, таван зүйл бүхий энэхүү гэрээг байгуулснаас хойшхи 30 жилийн хугацаанд тухайн үеийн байдлаас шалтгаалан монгол, хятадын харилцаанд сөрөг хандлага, зохисгүй үзэгдлүүд гарч, хоёр улсын харилцаа 20 гаруй жилийн турш хэвийн бус байдалтай байлаа. Ийм нөхцөлд ч хоёр орны ард түмний ажил чухал эрх ашгийг урьтал болгон сайн хөршийн найрсаг харилцаатай байх чиг шугам баримтлагчид аль аль талдаа олон байсан нь эргэлзээгүй юм.

Сүүлийн жилүүдэд хоёр талын идэвх санаачлага, хүч чармайлтын үрээр БНМАУ, БНХАУ-ын харилцаа бүрэн хэвийн болж, улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн салбарын хамтын ажиллагаа мэдэгдэхүйц өргөжлөө.

МАХН, ХКН-ын харилцаа сэргэж, улс төрийн яриа хэлэлцээ тогтмолжиж, түвшин нь байнга дээшилж ирэв. БНМАУ, БНХАУ-ын Засгийн газрын хооронд Консулын конценц, Хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай гэрээ, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комисс байгуулах тухай, иргэд харилцан зорчих журмын тухай, БНМАУ-ын ерөнхий консулын газрыг БНХАУ-ын Хөх хотод сэргээн байгуулах тухай, эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай, Байгаль орчныг хамгаалах, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухаан, техникийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр зэрэг чухал баримт бичгүүдэд гарын үсэг зурснаар харилцааны эрх зүйн үндэс улам баяжлаа.

Хоёр орны найрамдлын байгууллага, үйлдвэрчин, залуучууд ба олон нийтийн бусад байгууллагууд харилцаагаа мөн сэргээж, идэвхтэй хамтран ажиллаж байна.

Худалдаа, эдийн засгийн харилцаа жилээс жилд өргөжиж байна.

1986 оны 4-р сард гарын үсэг зурсан БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 1986—1990 оны худалдааны удаан жилийн хэлэлцээр ёсоор хоёр талын худалдааны нийт эргэлтийн хэмжээ 51,4 сая швейцар франкад хүрэх байсан боловч одоо худалдаа тэр үед бодож төлөвлөж байснаас 3 дахин өсч, 140 сая шв. франкад хүрч байна. 1990 онд Засгийн газар хоорондын худалдааны протокол ёсоор нийт бараа эргэлт 1989 оны протоколын дүнгээс 70 гаруй хувиар өсөх ажээ.

Хоёр улсын хоорондын хил орчмын худалдаа 1985 оноос эхлэж, 1989 онд 37 сая шв, франкад хүрэв. Мөн худалдааны төв компаниудын хооронд 1989 онд 9 сая шв, франкийн худалдаа хийжээ.

БНХАУ-ын Засгийн газраас БНМАУ-ын Засгийн газарт 1958, 1960 онуудад олгосон зээл, түүний хүүг төлөх талаар хэлэлцээ хийж, холбогдох протоколд 1986 онд гарын үсэг зурснаар олон жил шийдэгдээгүй байсан асуудлыг шийдвэрлэв.

Төмөр замын байгууллагуудын хооронд шууд харилцаа тогтож, хамтын ажиллагаагаа хөгжүүлсээр байна. Түүний зэрэгцээ Улаанбаатар-Бээжингийн агаарын нислэгийг 1986 онд сэргээж, одоо тогтмол нислэг хийж байна. Энэ нь тус хоёр орны хоорондын зорчигч тээвэр, олон улсын жуулчлалыг хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлж байгаа юм.

БНМАУ, БНХАУ-ын Засгийн газрын хооронд 1958 онд байгуулсан соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн үндсэн дээр сүүлийн жилүүдэд тус хоёр орны соёлын харилцаа сэргэн хөгжиж байна.

1986 оноос хоёр орны хооронд нэг, хоёр жилийн хугацаатай соёлын солилцооны төлөвлөгөөнд гарын үсэг зурж, түүний дагуу урлагийн хамтлагууд айлчлан тоглох, уран зураг, гар урлалын үзэсгэлэн гаргах, зохиолч, эрдэмтэн, тамирчид харилцан айлчлах зэрэг төрөл бүрийн ажил, арга хэмжээнүүд зохиогдож байна. Уг төлөвлөгөө ёсоор адил тооны мэргэжилтэн багш, оюутан, мэргэжил дээшлүүлэгч, аспирант харилцан илгээж, уран сайхны болон баримтат кино, ном хэвлэл, дуу хөгжмийн бичлэг солилцон, киноны өдрүүд зохиогдож ирлээ.

Мөн БНМАУ, БНХАУ-ын хооронд шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах хоёр жилийн хугацаатай төлөвлөгөө ёсоор хөдөө аж ахуй, хөнгөн, хүнс, түлш эрчим хүчний салбарын чиглэлээр хамтран ажиллаж, гол нь туршлага солилцож байна.

Сүүлийн жилүүдэд хоёр орны хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжиж, ном зохиол харилцан орчуулж хэвлэх сонирхол эрс дээшилж байна.

Монгол, Хятадын харилцаа бүх талаар ийнхүү сэргэн идэвхжсэн үед БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга П. Очирбат БНХАУ-ын дарга Ян Шанкуний урилгаар саяхан БНХАУ-д албан ёсны найрсаг айлчлал хийсэн нь тус хоёр орны харилцааны түүхэнд шинэ хуудас нээв. Энэ айлчлалын үеэр гаргасан Монгол, Хятадын хамтарсан албан мэдээнд «1960 онд байгуулсан БНМАУ, БНХАУ-ын хоорондын найрамдал, харилцан туслалцах тухай Гэрээг цаашид ч тулгуур үндэс болгон төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмын үндсэн дээр хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны харилцааг бэхжүүлэн хөгжүүлэхээ хоёр улсын удирдагчид нотлов» хэмээн заасан нь хоёр талын харилцааны үндсэн зарчмуудыг БНМАУ, БНХАУ дээд хэмжээнд баталгаажуулсан хэрэг

бөгөөд энэхүү айлчлалын нэг чухал үр дүн болов. Мөн энэ айлчлалын үеэр Монгол, Хятадын Засгийн газрын хооронд шинжлэх ухаан-техник, байгаль орчин, эрүүлийг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд байгуулж, тус хоёр улсын хилийг энх тайвны хил болгох, хил залгаа нутгийн иргэд харилцан зорчих, бараа солилцоог нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлэх, манай улсад жижиг, дунд үйлдвэр байгуулах талаар хамтран ажиллах, Монголын тал Хятадын нутгаар дамжин далайд гарах эрхийг хэрэгжүүлэх зэрэг худалдаа, хамтын ажиллагааны асуудлыг тодорхой шийдэхээр тохиролцсоныг хоёр орны харилцааг цаашид өргөжүүлэхэд дорвитой хувь нэмэр болно гэж уг айлчлалтай холбогдуулан гаргасан АИХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолд тэмдэглэжээ.

Монгол, Хятадын харилцаа ийнхүү хэлбэрэлтгүй сайжирч байгаа нь хоёр орны ард түмний язгуур эрх ашигт зүй ёсоор нийцэх төдийгүй Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд зохих тус дэм үзүүлж байна.

Өдгөө манай Засгийн газраас өмнөд их хөрш БНХАУ-тай харилцаагаа шинэ агуулгаар баяжуулан хөгжүүлж, ард түмнүүдийн язгуур эрх ашгийг илэрхийлсэн, орчин үеийн өндөр үр ашигтай хамтын ажиллагааны шинэ загварт шилжих чиг бодлогыг баримталж байгаа юм.

Харин 1960 оны уг гэрээний үзэл санаа өнөөдөр хуучраагүй, хойшид ч ач холбогдлоо алдахгүй бөгөөд өнө удаан жилийн түүхтэй, олон талын туршлага, хүчин зүйл бүхий Монгол, Хятадын харилцааг цаашид хөгжүүлэх өргөн боломжид бүрэн нийцэх нь дамжиггүй.